



**ТАХЬКО (ХК) КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж-18, УБД 9010001029  
Утас +976-11-324738, Факс +976- 11-325051  
И-мэйл: info@takhico.mn, Вэб хуудас: www.takhico.mn

2014. 03. 28 № 15  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХӨРӨНГИЙН БИРЖ (ХК) КОМПАНИД**

**Тайлан хүргүүлэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын “Хоёр”-ын 2.4-т заасны дагуу Тахько (ХК) компанийн 2013 оны үйл ажиллагааны товч тайланг хүргүүлэв.

ДАРГА

Л.БУЯНБАТ



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Тахько (ХК) компанийн үндэслэгч байгууллага нь анх 1931 онд Оёдлын артель нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1972 онд хоршоологчдын өмчөөс улсын өмчид шилжих, дотроо оёдлын төв үйлдвэр, хуухдийн хувцасны үйлдвэр, гэр ахуйн эдлэлийн үйлдвэр гэсэн турван үйлдвэрийг нэгтгэсэн Оёдлын үйлдвэрийн нэгдэл болж, тухайн үеийн Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн Яамны харьяанд ажиллаж байсан.

Улс орон зах зээлд шилжих эхний үед Оёдлын үйлдвэрийн нэгдэл нь Тахь пүүс, оёдлын Хулан, Оюу, Номин үйлдвэрлэл гэсэн зохион байгуулалтын хэлбэрээр бодино хугацаанд ажилласан бөгөөд Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдаж, Тахько хувьцаат компани байгуулагдсан.

Тус компани үүсгэн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр тогтоосон хугацаанд зарлан хуралдуулж, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх ажиллагааг хууль тогтоомжид заасан нөхцөл, журам, шаардлагын дагуу хэрэгжүүлж хэвшүүлж ирсэн ба хувьцаа эзэмшигчдэд 1993-2013 онуудад нийтдээ 453,786.1 мянган төгрөгийн ногдол ашиг олгоод байна.

Тус компани нь үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээ; гадаад дотоод худалдаа; хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг, улсын төсөвт болон нийгмийн даатгал, татварын байгууллагад өр төлбөргүй болно.

\* \* \*

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2013 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зарлан хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналын эрхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуульд заасан эрхийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн шаардлагын дагуу ээлжит бус хурлыг 2013 оны 08 сарын 28-ны өдөр зарлан хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг мөн хуралд оролцогчдийн саналын эрхийн олонхоор шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Т.Тамир, Л.Галбадрах, Л.Батбилэг, хараат бус гишүүнээр Б.Батхуяг, Б.Бямбасүрэн, С.Итгэл нар, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Л.Буянбат, Гүйцэтгэх захирлаар Л.Энхнасан нар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал нарын 90 хувь нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөл 2013 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг биелүүлж, бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайлангийн хугацаанд 8 удаа хуралдаж, 14 асуудал хэлэлцэж, 34 заалт бүхий 14 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын; цалин урамшууллын; нэр дэвшүүлэх байнгын хороодыг байгуулан, тэдгээр хорооны үйл ажиллагааны журмыг батлан мөрдөж байна.

Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгالت хийлгэж байх аудитын компаниар Юнистар аудит компани, аудитороор мөн компанийн аудитор Н.Энхжаргалыг сонгон ажиллуулав.

Компанийн ногдол ашгийн бодлогын журмын дагуу 2012 цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг 56 төгрөгөөр тогтоож, 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 652 хувьцаа эзэмшигчдэд 66,639,048 төгрөгийн ногдол ашиг хуваарилж, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан хувьцаа эзэмшигчдэд олгох ажлыг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид тайлагнасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс хүлэмжийн хийг бууруулах салхин цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэгч Клинтек компанийтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хийж ирсэн байна.

Тахько (ХК) компанийн захиргаа 2013 онд (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажиллаа.

Компанийн захиргаа тайлангийн хугацаанд удирдлага, захиргааны ба техник үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй, ажлын байрны 23 орон тоо бүхий бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан 2013 онд хэрэгжүүлэх ажлын болон үр ашиг, мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөт зорилтоо биелүүлж ажилласв.

Компани тайлангийн хугацаанд үндсэн түрээслэгч Ньюотел (ХХК) компанийн байгуулсан удаан хугацааны гэрээний үндсэн дээр компанийн үл хөдлөх хөрөнгө (офис, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий бүх барилга)-ийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээс, үйлчилгээний тогтолц орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгсэлийн, нэмэгдсэн өргтийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 167,153.8 мянган төгрөгийн татвар, нийгмийн даатгалд 61,024.5 мянган төгрөгийн шимтгэл төлж, төсөвт төлөх төлберийн 97.1 хувийг тайлангийн жилд барагдуулжээ.

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газар, Герман улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуух зээлийн санхүүжилтээр 1992 онд үйлдвэрлэх бүтээгдэхүүний бараа, материал авч, түүний төлбөрийг тухайн жилд нь төлж барагдуулсан боловч Сангийн Яамнаас уг төлбөрийн үлдэгдэл гэх 245,000 ам.доллар буюу 348,608,050 төгрөгийг төлөөгүй гэж шүүхэд нэхэмжлэл гаргасныг компанийн зүгээс уг төлбөрийг төлсөн болохыг нотлох баримтаар тогтоолгож, Сангийн яамны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүллээ.

Компани 2013 онд 1,078,657.6 мянган төгрөгийн орлоготой, 764,549.7 мянган төгрөгийн зарлагатай, 281,547.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан, 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 147,998.4 мянган төгрөгөөр, зардал 112,694.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансийн ашиг 35,304.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Зардлыг бүтцээр нь авч үзвэл нийт зардлын 95.84 хувийг үндсэн үйл ажиллагааны, 3.1 хувийг үндсэн бус үйл ажиллагааны, 1.06 хувийг борлуулалт удирдлагын зардал эзэлж байна. Нийт зардлын 37.7 хувийг цалин, түүнтэй адилтгах зардал, 16.2 хувийг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшуулалт, бусад зардал, 5.8 хувийг хэрэглэсэн дулаан, цахилгаан, усны зардал, 1.5 хувийг цахилгаан, дулааны тоног төхөөрөмж, барилгын урсгал засварын, 2.6 хувийг газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн татвар, 8.4 хувийг үндсэн ба биет бус хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл, 2.5 хувийг тээврийн хэрэгсэлийн сэлбэг, үйлчилгээ, шатахууны зардал, тэдгээрийн татвар, 1.7 хувийг холбоо, интернет, хэвлэлийн зардал, 2.6 хувийг албан томилолтын, 3.1 хувийг үйл ажиллагааны бус, 3.2 хувийг харуул хамгааллалтын, 14.7 хувийг бусад зардал эзэлж байна. Тайлангийн хугацаанд зардал нийт дүнгээр 25,083.3 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

Компани 2013 оны тайлан тэнцлээр 1,950,969.1 мянган төгрөгийн хөрөнгө, үүнээс 1,597,454.2 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй болсон бөгөөд тайлангийн хугацаанд 51,595.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тахько (ХК) компанийн нийтэд чөлөөтэй арилжаалагдсан энгийн хувьцааны арилжааны 2013 оны жилийн дундаж ханш 7,324 төгрөг, дансны дундаж үнэ 1,620 төгрөг болж, компанийн зах зээлийн үнэлгээ 2013 оны эцсээр 12,649,519,290 төгрөгт хүрч, 2013 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр нийт хөрөнгийн өгөөж 0.1443, хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж 0.146 хувь, нэгж хувьцааны өгөөж 236.5977, үнэ ашгийн харьцаа 44.9286 төгрөг болсон байна.

Компанийн тайлант хугацааны жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Юнистар компаниар хөндлөнгийн аудит хийлгүүлж, дүгнэлт гаргуулав.

Санхүүгийн тайлангийн хураангуй ба эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дор дурдсан байдлаар танилцуулж байна. Үүнд:

(төгрөгөөр)

Балансын зүйл	Үлдэгдэл		Балансын зүйл	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн		Эхний	Эцсийн
A. Хөрөнгө	x	x	B. Өр төлбөр эзэмшигчийн өмч	x	x
I. Эргэлтийн хөрөнгийн дүн	858,609,134.64	1,088,836,076.16	I. Өр төлбөрийн дүн	19,601,721.47	22,539,328.53
Мөнгөн хөрөнгө	361,136,207.27	592,016,719.46	Богино хугацаатай өр төлбөр	19,601,721.47	22,539,328.53
Богино хугацаатай хөрөнгө оруулалт			Үрт хугацаатай өр төлбөр		
Авлага	460,192,264.74	453,531,869.07	Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр		
Бараа, бэлэн бүтээгдэхүүн	36,070,962.63	42,100,037.63	II. Өмчийн дүн		
Үндсан ба туслах материал			Төрийн		
Урьдчилж төлсөн тооцоо	1,209,700.00	1,187,450.00	Хувийн		
Бусад			III. Хувьцаа дүн	199,917,144.00	199,917,144.00
II. Биет хөрөнгийн дүн	784,527,831.01	772,531,190.13	Энгийн хувьцааны тоо, ширхэг	1,189,983	1,189,983
Барилга байгууламж	1,150,890,072.40	1,197,729,870.98	Нэрлэсэн үнэ	168	168
Газар			Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг		
Машин тоног төхөөрөмж	18,478,102.73	18,478,102.73	Нэрлэсэн үнэ		
Тавилга, эд хогшил	129,683,190.46	145,445,161.30	Халаасны хувьцааны дүн		
Бусад, тээврийн хэрэгсэл	246,648,628.12	235,641,930.00			
Хуримтлагдсан эзлэгдэл	761,172,162.70	824,763,874.88	IV. Эзэмшигчийн өмчийн бусад хасэг	387,604,403.30	387,604,403.30
III. Биет бус хөрөнгийн дүн	1,985,440.64	1,600,967.89	V. Хуримтлагдсан ашиг	1,126,000,057.52	1,340,908,278.35
			Үүнээс: Тайлант үеийн ашиг	247,932,641.99	281,547,268.83
IV. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	88,000,920.00	88,000,920.00	VI. Эзэмшигчийн өмчийн дүн	1,713,521,604.82	1,928,429,825.65
Нийт хөрөнгийн дүн	1,733,123,326.29	1,950,969,154.18	VII. Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	1,733,123,326.29	1,950,969,154.18

Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төгрөгөөр)

Он	1992	1993	1994 1995	1998 1999	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Төгрөг	8.55	2.41	5.48 5.48	28.60	16.25	18.12	36.00	45.00	56.00	56.00	56.00	56.00

#### Эдийн засгийн үзүүлэлт

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2011	2012	2013
1. Цэвэр борлуулалт	997,621.5	930,659.2	1,364,520.0
2. Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг			
3. Үйл ажиллагааны зардал	714,394.3	651,855.7	1,050,412.1
4. Ашиг	283,227.2	278,803.5	314,107.9
5. Хувьцааны арилжааны дундаж ханш (төгрөгөөр)	4,291.36	5,772.04	7,324.10
6. Хувьцааны дансны үнэ (төгрөгөөр)	1,287.60	1,439.95	1,620.55
7. Хувь нийлүүлэгчдийн тоо	636	626	623
8. Хувьцааны төвлөрлийн хувь	84.29	79.25	83.93

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хууль, компанийн ногдол ашигийн бодлогын журмыг үндэслэн, өмнөх онд нэгж хувьцаанд хувиарласан ногдол ашигийн хэмжээг нэмэгдүүлж 2013 онд олсон цэвэр ашгаас нэгж хувьцаанд ногдох ногдол ашигийн хэмжээг 65 төгрөгөөр тогтоож, нийт энгийн хувьцаа (1,189,983 ширхэг)-нд 77,348,895 төгрөг хуваарилах шийдвэр гаргаж, энэ тухайг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, 2014 оны 05 дугаар сарын 01-

ний дотор Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлээд байгааг мэдээлж байна.

Тайлангийн хугацаанд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

2013 онд санхүү, эдийн засгийн орчин, бараа үйлчилгээний үнэ, инфляцийн түвшин зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлдөг нөхцөл нь сайнгүй байсан боловч Гүйцэтгэх удирдлага идэвх зүтгэлтэй ажиллаж компанийн санхүү, эдийн засгийн гол гол үзүүлэлт дээшилсэн байна.

Компанийн авлагыг барагдуулах ажлыг гүйцэтгэсэн боловч хөндлөнгийн аудитын зөвлөсөн олон жил болсон найдваргүй авлагыг шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлж чадаагүй байна.

Сүүлийн жилүүдэд түрээсийн орлого зонхицж 2002-2013 онуудад нийт орлогын 60.0-78.9 хувьд эргэлдэж байна. Тиймээс шинээр байнгын тогтмол орлоготой бизнесийг 2014 онд эхлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Компанийн 2013 оны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн болон Гүйцэтгэх захирлын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцээд компанийн гүйцэтгэх удирдлага, алба, ажилтнууд 2013 оны үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелүүлж ажилласан гэж дүгнэсэн болно.

Тахько (ХХ) компани Мобикомын үйлчилгээ үзүүлэгч Ньютел (ХХК) компанитай 2004 онд байгуулсан 10 жилийн хугацаатай их хэмжээний хэлцэл (түрээс, үйлчилгээний гэрээ)-ийн дагуу компанийн үл хөдлөх эд хөрөнгө (офис, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий бүх барилга)-ийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээс, үйлчилгээний тогтмол орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллаж ирсэн билээ.

Ньютел (ХХК) компанитай байгуулсан энэ их хэмжээний хэлцэл (түрээс, үйлчилгээний гэрээ) 2014 оны 07 дугаар сарын 27-ны өдөр дуусгавар болох тул түрээслэгч талын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байдал, цаашид тус компанийн үл хөдлөх хөрөнгийг түрээсээр үргэлжлүүлэн эзэмшиж, оруулсан хөрөнгө оруулалт, бий болгосон үйлчилгээний стандартыг хөгжүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулах талаар тавьсан санал, 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үндэслэн зах зээлийн бодит үнэ, ханш дээр сууринсан, харилцан ашигтай ажиллах зарчмыг үндэс болгосон их хэмжээний хэлцлийг шинээр хийхээр төлөвлөж, судалгаа, төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, шинээр их хэмжээний хэлцэл хийснээр түрээсийн орлогоос олох тус компанийн жилийн орлогын хэмжээ өмнөх хэлцлийн жилийн орлогоос нэмэгдэх боломж бий болох юм. Өмнөх хэлцлийн хугацаа дуусах үед их хэмжээний хэлцэл (түрээс, үйлчилгээ, ашиглалтын)-ийг шинээр байгуулж, компанийн дүрэмд заасан үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж, компанийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг зүйтэй гэж үзэж байна.

Компанийн эзэмшигчдийн эзлжит хурлыг 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10.00 цагаас компанийн байр (Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуунийн гудамж-18)-нд хуралдуулахаар товлож, дор дурдсан асуудал хэлэлцүүлэхээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн болно. Үүнд:

- Компанийн 2013 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах.
- Компанийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх түрээсийн гэрээ байгуулах их хэмжээний хэлцэл хийхийг батлах.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.

Нийт хувьцаа эзэмшигчдийг өөрсдийн үйлчилүүлдэг брокер, диллерын компани дээр очиж эзлжит хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, хуралд оролцохыг урьж байна.

Компанийн [info@takhico.mn](mailto:info@takhico.mn) хаягаар санал хүсэлтээ илгээж, мэдээлэл авч болно.

TAXHKO (ХХ) KOMPANI